Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 03 сарын 28-ны өдрийн 4294 дугаарт бүртгэв.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 25 өдөр Дугаар 94 Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 221 дүгээр тогтоолоор баталсан "Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам", Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв, Зүүн, Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифыг нэгдүгээр, айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг хоёрдугаар, тоолуургүй ахуйн хэрэглэгчдийн цахилгааны төлбөр тооцох сарын дундаж цахилгааны хэрэглээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ Б.АМАРСАНАА

241
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын 1-3-д оруулав. D:\Ajil\Khoroonii khural\Khoroonii khural 2019

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн
94 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Эрх зүйн хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 03 сарын 28-ны 4294 дугаарт бүртгэв.

## ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

| № | Ангилал | Хэмжих нэгж | Тариф |
|---|---|---|---|
| 1 | ***Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр*** | | |
| | *Үүнд: Нүүрс олборлолт, боловсруулалт*<br>*Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт*<br>*Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт*<br>*Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт*<br>*Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт* | | |
| **1.1** | Энгийн тоолууртай | Төг/кВт.ц | 155.90 |
| **1.2** | 3 тарифт тоолууртай | | |
| а | Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 155.90 |
| б | Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 276.00 |
| в | Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 77.10 |
| 2 | ***Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага*** | | |
| **2.1** | Энгийн тоолууртай | Төг/кВт.ц | 140.59 |
| **2.2** | 3 тарифт тоолууртай | | |
| а | Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 140.59 |
| б | Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 221.89 |
| в | Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 89.19 |
| **2.3** | "Цахилгаан тээвэр" ХК | Төг/кВт.ц | 89.19 |
| 3 | ***Улаанбаатар хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны гэрэлтүүлэг*** | | |
| **3.1** | 10, 11, 12, 1, 2, 3 дугаар сарууд | | |
| а | Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 19.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 140.59 |
| б | Орой, шөнийн хэрэглээ /оройн 19.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 89.19 |
| **3.2** | 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр сарууд | | |
| а | Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 140.59 |
| б | Орой, шөнийн хэрэглээ /оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 89.19 |

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
20 19 оны 03 сарын 28

*Эрчим хүчний зохицуулах хорооны*
*2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн*
*94 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 03 сарын 28-ны 4294

## АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

| № | Ангилал | Хэмжих нэгж | Тариф |
|---|---|---|---|
| 1 | ***Энгийн тоолууртай*** | | |
| а | Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэлх хэрэглээг | Төг/кВт.ц | 110.49 |
| б | Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээших хэрэглээг | Төг/кВт.ц | 130.29 |
| 2 | ***2 тарифт тоолууртай*** | | |
| а | Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 116.39 |
| б | Орой, шөнийн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/ | Төг/кВт.ц | 89.19 |
| 3 | ***Сарын суурь тариф*** | Төг/сар | 2,000.00 |

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.

241
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2019 01 28

*Эрчим хүчний зохицуулах хорооны*
*2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн*
*94 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт*

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2019-03-28
4294

## АХУЙН ТООЛУУРГҮЙ ЦАХИЛГААН ХЭРЭГЛЭГЧДИЙН ТӨЛБӨР ТООЦОХ САРЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ

1. Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

| № | Ангилал | Хэмжих нэгж | Сарын хэрэглээ |
|---|---|---|---|
| 1 | Айл өрх | кВт.ц | 350 |

241
ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019. оны 03. сарын 28.-ны өдрийн 4306 дугаарт бүртгэв.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 25 өдөр | Дугаар 106 | Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 221 дүгээр тогтоолоор баталсан "Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам", Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төвийн бүсийн хүрээнд мөрдөх нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг хавсралтаар батлсугай.

2. Батлагдсан тарифыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ Б.АМАРСАНАА

Дугаар 254
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

*Эрчим хүчний зохицуулах хорооны*
*2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн*
*106 дугаар тогтоолын хавсралт*

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 03 сарын 28-ны ... 4306 ... бүртгэв.

# ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭНИЙ ХҮРЭЭНД МӨРДӨХ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ХЭРЭГЛЭГЧДЭД МӨРДӨХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

| № | Бүсийн ялгаа | Сарын хэрэглээ (кВт.ц) | Тариф /НӨАТ-гүй/ (төг/кВт.ц) |
|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар хот | 100 кВт.ц хүртэл | 60.29 |
| | | 101 кВт.ц - аас дээш | 81.39 |
| 2 | Дархан хот, Эрдэнэт хот | 75 кВт.ц хүртэл | 60.29 |
| | | 76 кВт.ц - аас дээш | 81.39 |
| 3 | Бусад /1 ба 2 дугаар мөрүүдэд орохгүй бүх аймаг, сум / | 50 кВт.ц хүртэл | 60.29 |
| | | 51кВт.ц - аас дээш | 81.39 |

254
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
20 19 оны 03 сарын 25 ...

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019. оны 03. сарын 28-ны
өдрийн 4314 дугаарт бүртгэв.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 25 өдөр Дугаар 114 Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 5 дугаар зүйлийн 5.6.3, 11 дүгээр зүйлийн 11.2, 11.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв, Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 23.79 төг/кВт.ц-аар тогтоосугай.

2. Батлагдсан сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф дээр нэмж тооцон, цахилгааны төлбөрийн нэхэмжлэлд сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифын төлбөрийн дүнг тусгаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ Б.АМАРСАНАА

Бүртгэлийн дугаар 225
ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
20 19 оны

Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын 1-3-д оруулав.

D:\Ajil\Khoroonii khural\Khoroonii khural 2019